

## Дундговь аймагт гарч байгаа малын гоц халдварт Шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээний талаар

2018.04.26 ний өдрийн байдлаар

**Баянжаргалан** сумаас зүүн хойш 21 км -т “Майнт”-д өвөлжиж байгаа малчин Ц нь 2017 оны 12 сарын 20 ны өдөр мал доголсон гэсэн дуудлагын дагуу малд үзлэг хийж дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторит явуулан 2017 оны 12 сарын 21 ны хариу ирж Шүлхий өвчин болох нь тогтоогдсон.

Шүлхий өвчин оношлогдсонтой холбогдуулан аймгийн Онцгой комисс 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдөр хуралдаж МЭА-ны даргаар ахлуулан МХГ-ын улсын байцаагч, ОБГ-ын орлогч дарга, хорио цээрийн дэглэм сахиулах постод ажиллах аврагч гал сөнөөгч бүхий ажлын хэсгийг тус суманд ажлуулахаар томилон явуулсан.

Дээрхи ажлын хэсэг нь шинжилгээний хариуг үндэслэн Баянжаргалан сумын Засаг даргын орлогчийн А/75 дугаар захирамжийг гаргуулан хорио цээрийн дэглэмийг 2017 оны 12 сарын 22 ны өдрөөс эхлэн тогтоолгон мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажилласан. Баянжаргалан сумын Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 08-ний өдрийн 05 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Говь-Угтаал сүм** 2017 оны 12 дугаар сарын 22-ний өдөр Говь-Угтаал сумын Хонгор багийн малчин Т, М, Н нар нь Угтаал-Чандмань ХХК-ны эмчид дуудлага өгсний дагуу 5 үхрээс дээж авч УМЭАЦТ-т хүргүүлж шинжлүүлэхэд 12 дугаар сарын 25-ны өдөр “Шүлхий” өвчин болох нь тогтоогдсон.

Шинжилгээний хариуг үндэслэн сумын Засаг даргын 2017 оны 12 сарын 25 ний өдрийн А/106 тоот захирамж гарч хорио цээрийн дэглэм тогтоон ажилласан. Говь-Угтаал сумын Засаг даргын захирамжаар 2018 оны 2 дугаар сарын 08-ний өдөр “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Өндөршил сүм** 2018 оны 01 сарын 04-ний өдөр Өндөршил сумын 2-р багийн малчин Сүрэн, Ням нар нь тус сумын МЭҮТасгийн мэргэжилтэнд дуудлага өгсний дагуу 3 үхрээс дээж авч УМЭАЦТ-т хүргүүлж шинжлүүлэхэд 01сарын 06 ны өдөр “Шүлхий” өвчин болох нь тогтоогдсон.

Шинжилгээний хариуг үндэслэн сумын Засаг даргын 2018 оны 01 сарын 07 ний өдрийн А/03 тоот захирамж гарч хорио цээрийн дэглэм тогтоон ажилласан. Өндөршил сумын Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 08-ний өдрийн 11 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Цагаандэлгэр сүм** 2017 оны 12-р сарын 29-ний өдөр Цагаандэлгэр сумын нутаг Замын улаан гэдэг газраас малчин Ч.Даваасүрэнгийнхээс хонь доголох шинж тэмдэг илэрсэн, Гонжовын хоолой гэдэг газраас Б.Лхагвасүрэнгийнхээс үхрийн шүлс гоожих шинж тэмдэг илэрсэн гэсэн мэдээлэл авч 30-ны өдөр малын эмч П.Бурмаа уг дуудлагын дагуу явж өвчилсөн малаас дээж авч Улсын мал эмнэлэг ариун цэврийн төв лабораторид явуулсан.

Улсын мал эмнэлэг ариун цэврийн лабораториас 2018 оны 01-р сарын 03-ны өдөр шинжилгээний хариугаар халдварт Шүлхий өвчин болох нь тогтоогдсон.

Сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/01 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэм тогтоосон. Мөн сумын Засаг даргын 2018 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамжаар “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжиж” тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хорио цээрийн дэглэм бууртал түр хугацаагаар хориглосон. Цагаандэлгэр сумын Засаг даргын 2018 оны 2 дугаар сарын 08-ний өдрийн А/16 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Гурвансайхан сүм** 2018 оны 01 сарын 12 ны өдөр Гурвансайхан сумаас зүүн хойш 17 км “Нөмөр” гэх газар Чулуут багийн малчин Б.Баярмөнх-нь тус сумын Популяци ХХК-ны эмчид дуудлага өгсний дагуу очиж дээж авч УМЭАЦТЛ-т хүргүүлсэн. Дээжний хариу 2018

оны 01 сарын 17 ны орой ирж малын гоц халдварт “Шүлхий” өвчин болох нь тогтоогдлоо .

Шинжилгээний хариуг үндэслэн Гурвансайхан сумын Засаг даргын 2018 ны 01 сарын 15 ны өдөр дугаар А/07 захирамжийн дагуу хорио цээрийн дэглэмийг тогтоон ажилласан. Гурвансайхан сумын Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 13 -ний өдрийн А/30 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Дэрэн сум** 2018 оны 01 сарын 13 ны өдөр Дэрэн сумаас зүүн урагш 30 км “Хонхор хонд” гэх газар Бумбат багийн малчин Батбаяр нь мал доголсон гэх дуудлагыг Дэрэн-Уул ХХК эмчид өгсний дагуу очиж дээж авч УМЭАЦТЛ-т хүргүүлсэн. Дээжний хариу 2018 оны 01 сарын 16 ны орой хариу ирж малын гоц халдварт “Шүлхий” өвчин болох нь тогтоогдсон.

Шинжилгээний хариуг үндэслэн Дэрэн сумын Засаг даргын 2018 ны 01 сарын 15 ны өдөр дугаар А/07 захирамжийн дагуу хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэн ажилласан. Дэрэн сумын Засаг даргын 2018 оны 3 дугаар сарын 13 -ний өдрийн А/23 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Дэлгэрцогт сум** 2018 оны 02 сарын 07 ны өдөр Дэлгэрцогт сумаас зүүн хойш 28 км “Цахиурт” гэдэг газар нутагладаг /Төв аймгийн Баян-Өнжүүл сумын харъяат/ малчин А.Батсайхан, мөн аймгийн Бүрэн сумын малчин Д.Мөнхбаатар нарын үхэр шүлхий өвчний шинж тэмдэгтэй гэх дуудлага өгсний дагуу тус сумын малын их эмч болох Т.Нарангэрэл нь малд үзлэг хийж дээж авч УМЭАЦТЛ-т хүргүүлсэн. Дээжний хариу 2018 оны 02 сарын 14 ны өдөр хариу ирж малын гоц халдварт “Шүлхий” өвчин болох нь тогтоогдлоо .

Дэлгэрцогт сумын Засаг даргын 2018.02.07-ны өдрийн А/13 дугаар захирамжаар хорио цээрийн дэглэмийг хэрэгжүүлэн ажилласан. Голомтын бүсийг тойруулан хяналтын 11 цэгт 31 хүн, 12 техник хэрэгсэлтэйгээр ажилласан байна. Дэлгэрцогт сумын Засаг даргын 2018 оны 04 дугаар сарын 02 -ний өдрийн А/27 захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

**Адаацаг сум** 2018 оны 02 сарын 13 ны өдөр Адаацаг сумаас зүүн урагш 30 км Адьяабазар, Хатанбаатар, Төрмандах малчин нар нь мал доголсон гэх дуудлагыг, сумын МЭҮНэгжийн эмч Б.Төмөрчөдөрт өгсний дагуу малд очиж үзлэг хийж дээж авч УМЭАЦТЛ-т хүргүүлэн шүлхий өвчин болох нь батлагдсан.

Шинжилгээний хариуг үндэслэн Адаацаг сумын Засаг Даргын 2018 оны 02-р сарын 18 ны өдрийн А/20 дугаарын захирамжийн дагуу хорио цээр дэглэм тогтоон 11 постын гарган ариутгал халваргүйжүүлэлт хийн ажилласан.

2018 оны 03 сарын 06 ны өдөр Адаацаг сумын Өвөр худаг, Ар дов гэх газар нутаглаж байгаа Д.Мөнх-Очир, М.Ганхуяг нар нь мал догосон гэх дуудлагыг Адаацаг сумын малын их эмч Занад өгсөний дагуу малд очин үзлэг хийж шүлхий өвчний шинж тэмдэгтэй 7 үхрийг 2018 оны 03 сарын 07 ны өдөр устгаад байна. Д.Мөнх-Очирын 45 үхэр, Н.Энхсаруулын 16 үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулаад байна. 2018 оны 03 сарын 15 өдрийн байдлаар дээрхи айл өрхийн шүлхий өвчний шинж тэмдэгтэй 26 үхрийг устгаад байна. Эдгээр айлын бог малыг вакциндсан болно. Адаацаг сумын Засаг даргын 2018 оны 04 дугаар сарын 02 -ний өдрийн А/40 дугаар захирамжаар “Хорио цээрийн дэглэм”-ийг буулгасан.

Шүлхий өвчинтэй гарсантай холбогдуулан аймгийн авч буй арга хэмжээ:

-Аймгийн Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/531 “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”

- Засаг даргын 2017 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/75 “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай” , “Өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай”

-12 дугаар сарын 26-ны өдрийн А/76 “Архи согтууруулах ундаагаар үйлчлэхийг түр хориглох тухай”

-12 сарын 27-ны өдрийн А/77 “Ажлын хэсэг байгуулах тухай” зэрэг захирамжуудыг гарган мөрдөж ажилласан.

Мөн шүлхий өвчний тархалтыг хязгаарлах зорилгоор Дэрэн, Сайнцагаан , Гурвансайхан, Өлзийт сумдын эрүүл бүсийн босоо тэнхлэгийн дагуу дархлаажсан малын зурвас байгуулан зурвасын дагуу хамгаалалтын постыг 1-р сарын 16 ний өдрөөс 03-р сарын 12 ний өдрийг хүртэл ажиллуулсан.

**Малын өвчлөлийн талаар:**

| Сумын нэр    | Өрхийн тоо | Өвчилсөн мал |             |            |            |             |
|--------------|------------|--------------|-------------|------------|------------|-------------|
|              |            | Тэмээ        | Үхэр        | Хонь       | Ямаа       | Бүгд        |
| Баянжаргалан | 26         | 0            | 111         | 35         | 11         | 157         |
| Говь-Угтаал  | 19         | 0            | 31          | 17         | 7          | 55          |
| Цагаандэлгэр | 24         |              | 44          | 38         | 14         | 96          |
| Өндөршил     | 12         |              | 25          |            |            | 25          |
| Гурвансайхан | 20         |              | 23          | 29         | 27         | 79          |
| Дэрэн        | 65         |              | 192         | 366        | 360        | 918         |
| Дэлгэрцогт   | 4          |              | 131         |            |            | 131         |
| Адаацаг      | 19         |              | 473         |            |            | 473         |
| <b>Дүн</b>   | <b>189</b> | <b>0</b>     | <b>1030</b> | <b>485</b> | <b>419</b> | <b>1934</b> |

**Мал устгалын талаар:**

| Сумын нэр    | Өрхийн тоо | Устгасан мал |            |            |            |             |
|--------------|------------|--------------|------------|------------|------------|-------------|
|              |            | Тэмээ        | Үхэр       | Хонь       | Ямаа       | Бүгд        |
| Баянжаргалан | 26         | 0            | 111        | 35         | 11         | 157         |
| Говь-Угтаал  | 18         | 0            | 29         | 17         | 7          | 53          |
| Цагаандэлгэр | 22         | 0            | 44         | 11         | 7          | 62          |
| Өндөршил     | 11         |              | 20         |            |            | 20          |
| Гурвансайхан | 18         |              | 22         | 25         | 16         | 63          |
| Дэрэн        | 55         |              | 172        | 315        | 327        | 814         |
| Дэлгэрцогт   | 4          |              | 131        |            |            | 131         |
| Адаацаг      | 17         |              | 145        |            |            | 145         |
| <b>Дүн</b>   | <b>171</b> | <b>0</b>     | <b>674</b> | <b>403</b> | <b>368</b> | <b>1445</b> |

**Вакцинжуулалтын талаар:**

Эхний вакцинжуулалтыг 2017 оны 12-р сарын 27 –ноос 2018 оны 01-р сарын 17 ний өдрийг хүртэл явуулсан. Энэ вакцинжуулалт нь голомтонд байгаа бод болон бог, сэжигтэй бүсэд байгаа бүх үхрийг вакцинжуулсан.

Энэ ажлыг явуулахдаа аймаг, сумдын Засаг дарга нарын захирамжийг гаргуулан вакцин тарих нэг ажлын хэсгийг багийн Засаг дарга, малын их эмч, 2 - 3 баригчийн бүрэлдхүүнтэй томилон Баянжаргалан суманд 4, Говь-Угтаал суманд 3, Гурвансайхан суманд 2, Цагаандэлгэр 2, Өндөршил 3, Дэрэн суманд 3, ажлын хэсгүүдийг томилуулан ажилласан.

| Сумын нэр    | Тарих     | Тарьсан |      |      |      |           |      |
|--------------|-----------|---------|------|------|------|-----------|------|
|              | Малын тоо | Өрх     | Үхэр | Хонь | Ямаа | Малын тоо | %    |
| Баянжаргалан | 14719     | 116     | 4369 | 5400 | 4950 | 14719     | 100  |
| Говь-Угтаал  | 5585      | 105     | 3380 | 1516 |      | 4896      | 87.7 |

|              |              |            |              |              |              |              |             |
|--------------|--------------|------------|--------------|--------------|--------------|--------------|-------------|
| Цагаандэлгэр | 17000        | 114        | 1968         | 8138         | 6355         | 16461        | 96,8        |
| Өндөршил     | 2700         | 130        | 2342         |              |              | 2342         | 86,7        |
| Дэрэн        | 25000        | 33         |              | 12623        | 12497        | 25120        | 100         |
| Гурвансайхан | 15234        | 54         | 902          | 7391         | 6675         | 14968        | 97,7        |
| <b>Дүн</b>   | <b>80238</b> | <b>552</b> | <b>12884</b> | <b>35068</b> | <b>30477</b> | <b>78506</b> | <b>99,6</b> |

Вакцинжуулалтын ажил **80,2 мянган** мал хамрагдахаас **78,5 мянган** мал хамрагдаж **99,6%-ийн** гүйцэтгэлтэй дууссан байна.

Дараагийн буюу 2018 оны 03-р сарын 02 ны өдрөөс эхлэсэн вакцинжуулалтыг Хулд, Дэлгэрхангай, Сайхан-Овоо сумдуудын бүх бод бог, Эрдэнэдалай сумын Рашаант багийн үхрээс бусад бод бог малыг хамруулаагүй бөгөөд үлдсэн сумдын бүх бод мал, өвчин гарсан сумдын голомтонд байгаа бүх мал болон голомтыг тойруулан хамгаалалтын бүсийг байгуулан вакцинжуулах ажлыг зохион байгуулсан.

Энэ ажлыг явуулах даа аймаг, сумдын Засаг дарга нарын захирамжийг гаргуулан вакцин тарих нэг ажлын хэсгийг багийн Засаг дарга, малын их эмч, 2 - 3 баригчийн бүрэлдхүүнтэй томилон Адаацаг суманд 3, Дэлгэрцогт суманд 2, Гурвансайхан суманд 2, Дэрэн суманд 3, Сайнцагаан суманд 4, Баянжаргалан суманд 4, Цагаандэлгэр суманд 2, Луус суманд 3, Говь-Угтаал суманд 3, Өндөршил 3, Өлзийт суманд 3, Эрдэнэдалай /Рашаант баг/ 1 ажлын хэсгүүдийг томилуулан ажилласан.

| Сумын нэр                 | Тарих         | Тарьсан     |              |              |              |              |               | %           |
|---------------------------|---------------|-------------|--------------|--------------|--------------|--------------|---------------|-------------|
|                           | Малын тоо     | Өрх         | Үхэр         | Тэмээ        | Хонь         | Ямаа         | Малын тоо     |             |
| Адаацаг                   | 44200         | 315         | 5775         | 308          | 19545        | 18572        | 44200         | 100.0       |
| Дэлгэрцогт                | 35800         | 142         | 4832         | 12           | 13845        | 17111        | 35800         | 100.0       |
| Гурвансайхан              | 5900          | 181         | 4427         | 1398         | 0            | 0            | 5825          | 98.7        |
| Дэрэн                     | 36800         | 208         | 5310         | 899          | 13989        | 16011        | 36209         | 98,4        |
| Сайнцагаан                | 35800         | 257         | 5230         | 514          | 15083        | 14787        | 35614         | 99,5        |
| Баянжаргалан              | 3000          | 141         | 2823         | 148          | 0            | 0            | 2971          | 99.0        |
| Цагаандэлгэр              | 3300          | 99          | 2660         | 640          |              |              | 3300          | 100         |
| Луус                      | 5100          | 211         | 4641         | 360          | 0            | 0            | 5001          | 98.1        |
| Говь-Угтаал               | 2600          | 119         | 2279         | 178          | 0            | 0            | 2457          | 94.5        |
| Өндөршил                  | 5100          | 166         | 2801         | 2156         | 0            | 0            | 4957          | 97,2        |
| Өлзийт                    | 7200          | 76          | 2800         | 4400         | 0            | 0            | 7200          | 100.0       |
| Эрдэнэдалай /Рашаант баг/ | 5000          | 121         | 5000         | 0            | 0            | 0            | 5000          | 100.0       |
| <b>Нийт дүн</b>           | <b>189800</b> | <b>2036</b> | <b>48578</b> | <b>11013</b> | <b>62462</b> | <b>66481</b> | <b>188534</b> | <b>99,3</b> |

**Дээрх вакцинжуулалт нь 188,5 мянган мал хамрагдаж 99,3 хувьтай дууссан бөгөөд эзэнгүй зэлүүд яваа тэмээнээс бусад мал вакцинжуулалтанд хамрагдсан болно.**

| № | Сумын нэр  | Зориулалт     | Постын тоо | Хүн |        |            |      | Техник |     |
|---|------------|---------------|------------|-----|--------|------------|------|--------|-----|
|   |            |               |            | ОБГ | Цагдаа | Орон нутаг | Нийт | Машин  | Мот |
| 1 | Сайнцагаан | Хяналтын пост | 2          | 2   | 2      | 4          | 8    |        |     |

|   |             |                  |           |          |          |           |           |          |          |
|---|-------------|------------------|-----------|----------|----------|-----------|-----------|----------|----------|
| 2 | Дэлгэрцогт  | Хяналтын<br>пост | 11        | 4        | 2        | 25        | 31        | 3        | 9        |
|   | <b>Нийт</b> |                  | <b>13</b> | <b>6</b> | <b>4</b> | <b>29</b> | <b>39</b> | <b>3</b> | <b>9</b> |

Шүлхий өвчинтэй тэмцэх арга хэмжээг аймаг, сумын Онцгой Комисс, мэргэжлийн байгууллагууд хамтран дээрхи 2 суманд 13 постод 39 албан хаагч 12 техник ажилласан байна.

ХХААГ-ын хувьд байгууллагын даргаасаа эхлээд нийт 9 албан хаагч 119 хоног голомтонд томилолтоор ажиллаж Land 77 ДУА 36-38 631л түлш зарцуулж 4126 км, Фермер ДУА 71-91 355л бензин зарцуулж 1966 км, Пургон ДУА 39-49 170л бензин зарцуулж 944км явж 3 машинаар нийт 7036 км явж 1156 л бензин шатахуун зарцуулж албан үүргээ гүйцэтгэсэн байна.

“Шүлхий” өвчин оношлогдсон дээрх сумдуудад ХХААГазраас 1.073.670 төгрөгний өртөг бүхий 13 автомакс, , 10.470.937.5 төгрөгний өртөг бүхий 765 ш халдвар хамгааллын хувцас, 1.900.000 төгрөгний өртөг бүхий 475 тн хлорын шохой, 2.250.000 төгрөгний өртөг бүхий вамеком ариутгалын бодис 90кг, 694.741 төгрөгний өртөг бүхий HI-Cop ариутгалын бодис 31 кг зэрэг нийт 16389348.5 төгрөгний өртөг бүхий ариутгалын бодис, хөдөлмөр хамгааллын хувцас зэргийг гарган ажилласан байна.